



БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 12 сарын 22-ны
өдрийн 3671 дугаарт бүртгэв.

2018 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Газар хөдлөлийн бичил мужлалын зураг
ашиглах норм, дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 4.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тухайн нутаг дэвсгэрийн газар хөдлөлийн балл, хөрсний оргил хурдатгал, хөрсний зонхилох давтамж, түүний мужлалын хилийн солбилцол зэрэг техникийн үзүүлэлтийг ашиглах “Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм, дүрэм” БНБД 22-04-16-г хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын 1 дэх заалтад заасан “Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм, дүрэм”-ийн дагуу газар хөдлөлийн техникийн үзүүлэлтүүдийг дараах хот төлөвлөлтийн болон барилга байгууламжийн зураг төсөлд тусган баталгаажуулж ажиллах болон хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, инженер хайгуулын судалгааны ажил гүйцэтгэдэг байгууллагуудад мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Занабазар/, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ /Ц.Амарсанаа/, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /Ц.Ганхүү/-т тус тус ДААЛГАХ нь:

2.1. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг, барилга байгууламжийн зураг төслийн төлөвлөлт болон газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;

2.2. Зураг төсөл нь магадлалаар баталгаажсан боловч барилгын ажил нь эхлээгүй байгаа барилга байгууламжийн зураг төсөл.

3. Нийслэл болон дүүргүүдийн нутаг дэвсгэрийн газар хөдлөлийн техникийн үзүүлэлтүүдийг дараах барилгын үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /С.Батболд/-д ЗӨВЛӨСҮГЭЙ:

3.1. Барилгын ажлын зөвшөөрөл олгох, барилга байгууламжийг ашиглалтад оруулах зэрэг барилгын ажлын үе шат бүрт хяналт тавих;

3.2. Ашиглагдаж байгаа барилга байгууламжийн газар хөдлөлийн үйлчлэлд тэсвэрлэх чадварыг үнэлж, паспортжуулах;

08 00637

3.3.Нийслэл, дүүргийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг болон газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад газар хөдлөлийн эрсдэл багатай бүсэд барилга байгууламжийг төлөвлөх.

4.Өндөр болон онцгой төвөгшилтэй барилга байгууламж баригдах талбайн инженер геологийн дүгнэлтэд тусгасан газар хөдлөлийн үйлчлэлийг тодорхойлсон үзүүлэлтүүдийг “Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм, дүрэм” БНБД 22-04-16-д заасны дагуу хянан, зөвшилцөж байхыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Занабазар/, Шинжлэх Ухааны Академийн Одон орон, геофизикийн хүрээлэн /С.Дэмбэрэл/-д тус тус даалгасугай.

5.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д үүрэг болгосугай.

6.Барилга, хот байгуулалтын сайдын 2006 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 120 дугаар тушаалаар баталсан “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” БНБД 22.01.01*/2006-ийн 1-р хавсралт “Газар хөдлөлийн хүчийг баллаар авах заалттай газар хөдлөлтийн бүс нутагт байрласан Монгол Улсын хотуудын жагсаалт”-аас 12, 25 дахь заалтыг тус тус хассугай.

7.Тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн хамтарсан 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн №91/А383/А/64 дүгээр тушаал, захирамж, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын схем зураг батлах тухай” Барилга архитектурын комиссын 1980 оны 20 дугаар тогтоол, “Улаанбаатар хотын 1-10 дугаар бичил хорооллын газар хөдлөлтийн хүчийг баллаар авах тухай” Барилга архитектур техник хяналтын улсын хороо, Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн 1981 оны 69/743 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД *Т. Мөнхбаяр* Т.МӨНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ

Барилга, хот байгуулалтын сайдын
2016 оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн 198 дугаар тушаалын хавсралт

**“ГАЗАР ХӨДЛӨЛИЙН БИЧИЛ МУЖЛАЛЫН ЗУРАГ
АШИГЛАХ НОРМ, ДҮРЭМ”**

БНБД 22-04-16

1. Хэрэглэх хүрээ

1.1. Энэ дүрмээр хот, суурин газрын нутаг дэвсгэрт барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах барилгын ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулахад шаардагдах газар хөдлөлийн эрчмийн тоон үнэлгээ (цаашид балл гэх), хөрсний оргил хурдатгал, хөрсний зонхилох давтамж болон түүний мужлалын хилийн солбилцол зэрэг техник үзүүлэлтүүдийг газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглан тодорхойлох аргачлалыг тогтооно.

1.2. Ашиглагдаж байгаа барилга байгууламжийг паспортжуулахад энэ дүрмээр газар хөдлөлийн баллыг тодорхойлно.

1.3. Шинжлэх Ухааны Академийн баталсан “Хот, суурин газрын нутаг дэвсгэрийн газар хөдлөлийн балл, хөрсний оргил хурдатгал, хөрсний зонхилох давтамж болон түүний мужлалын хилийн солбилцол зэрэг техникийн үзүүлэлт”-үүдийг барилгын үйл ажиллагаанд тусгаж мөрдөнө.

2. Газар хөдлөлийн бичил мужлалын зургийн бүрэлдэхүүн

2.1. Газар хөдлөлийн бичил мужлалын зураг доорх бүрэлдэхүүнтэй байна.

- 2.1.1. Бичил мужлалын зураг
- 2.1.2. Газар хөдлөлийн бичил мужлалын солбилцол
- 2.1.3. Зонхилох давтамжийн зураг
- 2.1.4. Хөрсний оргил хурдатгалын бүсчлэлийн зураг

2.2. Хот, суурин газрын хөрсөнд илэрч болзошгүй газар хөдлөлийн чичирхийллийн хэмжээг бичил мужлалын зураг ашиглаж тодорхойлно.

2.3. Газар хөдлөлийн бичил мужлалын зургийг дараах байдлаар дугаарлана.

Шифр-АА-ОН-ГХБ-ХХ-УУ

- АА – Хот суурин газрын нэр
- ОН – Бичил мужлалын зураг боловсруулсан он
- ГХБ – Газар хөдлөлийн баллын зураг
- ХХ – Талбайд боловсруулсан зургийн нийт тоо
- УУ – Тухайн зургийн дугаар

2.4. Энэ дүрмийн 2.2 дахь хэсэгт заасан газар хөдлөлийн баллын бичил мужлалын хил заагийг солбилцлоор тодорхойлно.

2.5. Газар хөдлөлийн бичил мужлалын солбилцлын зургаар газар хөдлөлийн баллын хил заагийг тодорхойлно.

2.6. Газар хөдлөлийн бичил мужлалын зургийг солбилцлоор нь дараах байдлаар дугаарлана.

Polygon-XX-УУ

XX - Баллын бүсийн дугаар

УУ - Полигон (Polygon) тус бүрийн дугаар

2.7. Газар хөдлөлийн үйлчлэлээс барилга байгууламжид ирэх долгионы давтамжийг хөрсний зонхилох давтамжийн зургаар тодорхойлно.

2.8. Хөрсний зонхилох давтамжийн зургийг дараах байдлаар дугаарлана.

Шифр АА-ОН-ЗДМ-XX-УУ

АА - Хот, суурин газрын нэр

ОН - Хөрсний зонхилох давтамжийн зураг боловсруулсан он

ЗДМ - Хөрсний зонхилох давтамжийн мужлалын зураг

XX - Талбайд боловсруулсан зургийн нийт тоо

УУ - Тухайн зургийн дугаар

3. Газар хөдлөлийн бичил мужлалын зургийг ашиглах дэс дараалал

3.1. Газар хөдлөлийн бичил мужлалын зургийг ашиглаж газар хөдлөлийн чичирхийллийн хэмжээг дараах дэс дарааллаар тодорхойлно:

3.1.1. газар хөдлөлийн бичил мужлалын зургийн захад байрлуулсан тэгш өнцөгт солбилцлын системийн ординат-(y), абсцисс-(x) тэнхлэгүүдийн солбилцлыг тохируулан зургийг байрлуулна.

3.1.2. тухайн барилга байгууламжийн гадна булангийн цэгүүдийн солбилцлыг ашиглан энэ дүрмийн 3.1.1 дэх заалтад заасан зурагт барилга байгууламжийн байршлыг тодорхойлно.

3.1.3. барилга байгууламжийн байршлыг газар хөдлөлийн бичил мужлалын зурагт байршуулсны дараа энэ дүрмийн 4.1, 4.2, 4.3-д заасны дагуу тухайн газрын газар хөдлөлийн баллын хэмжээг тогтооно.

3.2. Хөрсний зонхилох давтамжийн мужлалын зургийг ашиглаж барилга байгууламжид нөлөө үзүүлэх долгионы давтамжийг дараах дэс дарааллаар тогтооно:

3.2.1. хөрсний зонхилох давтамжийн мужлалын зургийн захад байрлуулсан солбилцлүүдийг тохируулан тухайн газрын зургийг байрлуулна.

3.2.2. барилга байгууламжийн гадна хануудын огтлолцсон цэгүүдийн солбилцлыг ашиглан энэ дүрмийн 3.2.1 дахь заалтад заасан зурагт тухайн барилга байгууламжаа байрлуулна.

3.2.3. барилга байгууламжид газар хөдлөлийн үйлчлэлээс нөлөөлөх долгионы давтамжийн хэмжээг энэ дүрмийн 4.8, 4.9, 4.10-д заасны дагуу тодорхойлно.

Гарчиг	Хуудас
1. Хэрэглэх хүрээ	3
2. Газар хөдлөлийн бичил мужлал зургийн бүрэлдэхүүн	3-4
3. Газар хөдлөлийн бичил мужлал зургийг ашиглах дэс дараалал	4-5
4. Хөрсний оргил хурдатгал, газар хөдлөлийн балл болон зонхилох давтамжийг тодорхойлох	5-6
5. Барилга, байгууламжийн байршлыг газар хөдлөлийн үйлчлэлд тохируулан сонгох шаардлага	6